

САНГИЙН ЯАМ


**“Уул уурхайн салбарын төсөвт үзүүлж буй
нөлөө, эрсдэл”**

Санхүү, эдийн засгийн бодлогын газрын
мэргэжилтэн Г.Хандцоож

Агуулга

1. Уул уурхайн салбарын эдийн засагт болон төсөвт эзлэх байр суурь
2. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
3. Эрсдлүүд


1 Эдийн засгийн өнөөгийн байдал



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

- Монгол улсын эдийн засгийн өсөлт сүүлийн 14 жилийн хугацаанд 2002-2003 онуудын байгаль цаг уурын тааламжгүй байдалаас үүдэлтэй уналт болон 2009 оны дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралаас үүдсэн уналтаас бусад үед тогтвортой өндөр өсөлттэй байлаа. Энэ өсөлтийг хангахад уул уурхайн салбарын өсөлт 2001 оноос эхлэн онцгой байр суурь эзэлсэн.

1 Эдийн засгийн өнөөгийн байдал



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Сангийн яам

- Аж үйлдвэрлэлийн салбар, тэр дундаа уул уурхайн салбарын өсөлт томоохон байр суурийг эзэлж байна. Иймээс эдийн засгийн өсөлтийн бүтцийг авч үзэхдээ уул уурхай болон бусад салбараар нь салгаж авч үзэх шаардлага гарч байна. Ялангуяа уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж эхэлбэл суурь эдийн засагт ямар өөрчлөлт гарч байгааг анхааран авч үзэх шаардлага гарсан.

2 Уул уурхайн салбарын эдийн засагт болон төсөвт үзүүлж буй нөлөө



Эх үүсвэр: Монголбанк

- Эдийн засгийн бүхий л салбаруудад гарсан өсөлт, уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байгаагаас (non-renewable resources) үүдэж манай улсын гадаадын хөрөнгө оруулалтын тааламжтай байдлаас шалтгаалж гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ цэвэр дүнгээр 2010 оны 4 дүгээр улиралд 520.4 сая.ам долларт хүрсэн байна.
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр **1574 сая ам.долларт хүрч 2.8 дахин**, багцын буюу санхүүгийн хөрөнгө оруулалтын данс цэвэр дүнгээр **879 сая ам.долларын ашигтай гарсан нь санхүүгийн дансны ашгийг 3.2 дахин нэмэгдэхэд нөлөөлөв.**


2 Уул уурхайн салбарын эдийн засагт болон т өсөвт үзүүлж буй нөлөө

Экспортын бүтээгдэхүүний бүтэц		2008	2009	2010
Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	Хэмжээ, сая доллар	31,641.50	45,808.85	69,384.26
	Эзлэх хувь	1%	2%	2%
Эрдэс бүтээгдэхүүн	Хэмжээ, сая доллар	1,529,401.00	1,251,766.73	2,354,476.00
	Эзлэх хувь	60%	66%	81%
Арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	Хэмжээ, сая доллар	41021.0	29,043.85	32,532.40
	Эзлэх хувь	2%	2%	1%
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	Хэмжээ, сая доллар	226,542.80	192,166.58	216,340.84
	Эзлэх хувь	9%	10%	7%
Сувд, үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	Хэмжээ, сая доллар	600,172.60	308,525.20	178,351.47
	Эзлэх хувь	24%	16%	6%
Бусад	Хэмжээ, сая доллар	105,687.51	58,073.93	57,417.21
	Эзлэх хувь	4%	3%	2%

- Уул уурхайн салбар манай улсын экспортын 81 хувийг эзэлж байна.
- Монголын эдийн засгийн өсөлтийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд гол хөрөнгө оруулагч, эрэлтийг үүсгэгч тал нь БНХАУ бөгөөд түүний манай улсын уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт огцом нэмэгдсэн нь манай улсын бодит аж үйлдвэрлэлийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэхэд хүргэсэн. Өнгөрсөн онд нүүрсний үйлдвэрлэл 25 сая тоннд хүрч өмнөх оныхоос бараг хоёр дахин нэмэгдсэн, түүнчлэн аж үйлдвэрийн гол бүтээгдэхүүний үйлдвэрлэл болох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 24 хувиар, үндсэн метал үйлдвэрлэл 30 хувиар өссөн.

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

2 Уул уурхайн салбарын эдийн засагт болон төсөвт үзүүлж буй нөлөө




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, <http://nso.com>

- Нүүрс нь манай улсын хувьд нийт экспортод эзлэх хувь өссөөр байна.
- Хятад улсын нүүрсний эрэлт хэрэгцээ (2011 оны 1 дүгээр улирлын байдлаар БНХАУ-ын эдийн засаг 9.7 хувиар өссөн*) нэмэгдэж байгаа болон Австрали улсын нүүрсний экспортын бууралт зэрэг хүчин зүйлсийн улмаас манай улсын нүүрсний экспорт цаашид их хэмжээгээр нэмэгдэх хандлагатай байна.

*-www.stats.gov.cn

2 Уул уурхайн салбарын эдийн засагт болон төсөвт үзүүлж буй нөлөө

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2004-2011 оны эхний улирлын байдлаар



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, <http://nso.com>

Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтээр нь авч үзвэл, Алтны үйлдвэрлэл огцом багассан нь 2006 онд батлагдсан “зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн орлогын албан татварын тухай” хуулийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байсантай холбоотойгоор олт олборлогч компаниуд татвараас зугатаах, Монголбанкинд тушааж, борлуулах алтны хэмжээ багассан одоо ч энэ байдал сайжрахгүй байна. Харин нүүрсний олборлолт огцом нэмэгдсэнтэй холбоотойгоор зэсийн үйлдвэрлэлийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувийн жин багасч байна. Энэ оны эхний улирлын байдлаас харахад нүүрс олборлолт нийт олборлолтын 56 орчим хувийг эзэлж байна.

2 Уул уурхайн салбарын эдийн засагт болон төсөвт үзүүлж буй нөлөө

	2007	2008	2009	2010	2011	2012*	2013*
ЗБҮӨАТ	353.7	384.8	186.5	391.1	0	0	0
АМНАТ	94.4	109.1	107.9	158.9	200.3	220.3	242.4
Гусгай зөвшөөрөл (нөхөн төлбөрийн хамт)	40.1	35.7	35.4	28.5	30	30.9	31.8
ААНОАТ	128.2	121.4	88	186	266.8	293.5	322.8
Ногдол ашиг	135.6	21.1	104	55.9	54.4	190	218.2
Бусад татварт төлсөн	17.8	18.9	15.1	15.6	20.5	35.7	36.2
Гааль дээр төлсөн	12.8	15.5	16.5	30	100.5	28.7	32
Бусад /өсөн нэмэгдэх 2011 оноос/	19.2	20.4	0	0	207.7	228.5	251.3
Нийт дүн	801.8	726.9	553.4	866	880.2	1027.6	1134.7
Төсвийн нийт орлого	1880.5	2170.4	1993.9	2734.4	3260.7	3231.3	3542.9
Нийт орлогод эзлэх хувь	42.6	33.5	27.8	31.7	27.0	31.8	32.0

Эх үүсвэр: Сангийн яам


- Уул уурхайн салбараас төсвийн нийт орлогод эзлэх хувийн жин 2007-2008 онуудад зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараас үүдэлтэйгээр 42.6 хувьд хүрч байсан. ЗБҮӨАТ нь нийт орлогын 44 хувийг, ААНОАТатвар нь 17.5 хувийг АМНАТ нь 16.2 хувийг эзэлдэг. 2011 оноос эхлэн “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын” тухай хуулийг х үчингүй болгосноор өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийг эрдэс баялагийн бүтээгдэхүүнүүд дээр хэрэглэхээр болсон.

2 Уул уурхайн салбарын эдийн засагт болон төсөвт үзүүлж буй нөлөө


№	Бүтээгдэхүүний нэр төрөл	2010 ХБГ	2011 төсөв
1	Алт	38.2	68.8
2	Нүүрс	193.4	291.5
3	Зэс	543.8	436
4	Цай	34.2	29.6
5	Жонш	4.3	4.5
6	Бусад	52.1	49.8
	Нийт дүн	866.0	880.2

- Уул уурхайн салбарын татварын орлого, бүтээгдэхүүний төрлөөр авч үзвэл зэс нийт орлогын 50 гаран хувийг эзэлж байсан бол нүүрс 33 хувийг эзлэхээр байна. Нүүрс сүүлийн жилүүдэд алтыг орлон гол нэр төрлийн эрдэст баялагт тооцогдох болсон. (Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсвийн орлогын 3 хувь болон түүнээс дээш хувийг бүрдүүлж буй эрдэс баялагийг онцгойлон авч үзэхээр болсон)

2010 оны төсвийн орлогод уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хувь



2011 оны төсвийн орлогод уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хувь



3 Уул уурхайн салбар болон хямралын үр дагавар

Эрхлэхий
нийтийг
хамарсан
санхүү, эдийн
 засгийн
хямрал

Эрдэс баялагийн бүтээгдэхүүний үнийн өсөлт



Эрдэс баялагийн бүтээгдэхүүний үнийн огцом буурсан



Эрдэс баялагийн бүтээгдэхүүний орлогын өсөлт

Эрдэс баялагийн бүтээгдэхүүний орлого огцом буурсан

Гадаад худалдааны урсгал тэнцлийн алдагдал нэмэгдсэн (341.8 сая.ам долларт)

Төсвийн нийт орлого өснө

Төсвийн нийт орлого огцом буурсан

Төгрөгийн ханш суларсан 1 ам.доллар=1524.07 төгрөгт хүрсэн (2009.III сар)

600 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн

буураа гүй

Төсвийн зарлагыг нэмэгдсэн

Гадаад зээлээр санхүүжүүлсэн (500 гаруй сая ам.доллар)

Гадаад валютын нөөцөө алдсан 555.5 сая ам.доллараар

Зэрэгжих зэрэглэл буурсан B1 stable-> B1Negative (Moody's) BB stable-> BB negative (S&P)

Инфляци хөөрөгдсөн

Хөрөнгө оруулалтыг нэмэгдсэн (барилгын салбарын эрэлт өссөн)

Бэлэн мөнгө тарааж эрэлтийг нэмэгдүүлсэн

САНГИЙН ЯАМ

3 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

Дараах зорилтуудыг дунд хугацаанд хангах үүднээс ТТБТХуулийг УИХ 2010 оны 6 сард баталсан:

- Нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангах
- Төсвийн тусгай шаардлагуудыг тогтоох, хэрэгжүүлэх хяналт тавих (бусад уул уурхайд түшиглэсэн орнуудад өргөн хэрэглэдэг)
- Эрдэс баялагийн орлогоор нөхөн сэргээгдэх баялагийг бүтээх
- Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалтыг хийх
- Санхүүгийн хуримтлалыг бүрдүүлэх
- (7 бүлэг 19 зүйлтэй)

3 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

Төсвийн макро түвшний тогтворжилтыг хангах 4 төрлийн тусгай шаардлага байна. (олон улсын жишгийг харгалзан тодорхойлсон) Үүнд:

Хуулийн 6.1.Төсөвт дараахь тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна:

6.1.1.нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;

6.1.2.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;

6.1.3.тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;

6.1.4.уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хамааруулахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх.


Төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг жил бүр тодотгож тооцно.

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 4 жилд нэг удаа өөрчлөх.

3 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

- “гол нэр төрлийн эрдэс баялаг” гэж тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын 3 хувь, эсхүл түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялагийг хэлнэ. 2011-2014 онуудад нэгдсэн төсвийн орлогын 3 хувьтай тэнцэх орлого дараах байдалтай байна.

Тэнцвэржүүлсэн орлогын тусгай шаардлага




Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл=нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого(гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого { $Q \times \text{тэнцвэржүүлсэн үнэ}$ } + нэгдсэн төсвийн суурь орлого) - нэгдсэн төсвийн нийт зарлага

Тэнцвэржүүлсэн зэсийн үнэ: хувьд 2012 онд 6443 ам.доллар, 2013 онд 6970.8 ам.доллар, 2014 онд 7005.2 ам.доллар,
Тэнцвэржүүлсэн боловсруулсан нүүрсний үнэ: 2012 онд 151,1 ам.доллар, 2013 онд 158,8 ам.доллар, 2014 онд 160 ам.доллар

3 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

Төсвийн зарлагын тусгай шаардлага



3 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

- Төсвийн алдагдал нь шилжилтийн заалттай:
 - 2011 онд тусгай шаардлага үйлчлэхгүй.
 - 2012 онд тусгай шаардлага үйлчлэхгүй.
 - 2013 оноос хойш төсөв ашигтай эсвэл төсвийн алдагдал ДНБ-ий 2%-аас хэтрэхгүй.
- Өрийн түвшин шилжилтийн заалттай.
 - 50% 2011 онд
 - 60% 2012 онд
 - 50% 2013 онд
 - 40% 2014 оноос хойш

3 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

ТӨСӨВ ТОГТВОРЖУУЛАХ ГОЛ ХЭРЭГСЭЛ

Гол хэрэгсэл нь: Төсвийн огтворжуулалтын сан


- Төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагад нийцсэн нэгдсэн төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Төсвийн тогтворжуулалтын сантай байна.
- Тус санд тэнцвэржүүлсэн орлогоос давсан бүх орлогыг оруулна.
- Санг ямагт мөнгө хэлбэрээр хадгалж удирдана.
- Сан байгуулах минимум хэмжээ (\leq ДНБ-ний 5%)
- Сангийн эх үүсвэр бүрдүүлэлт, (төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан орлого, төсвийн ашиг, бусад)
- Сангийн хязгаарлагдмал зориулалт (зөвхөн төсөв тогтворжуулахад)
- Сангийн удирдлага, хяналт, тайлагнал (Энэ талаар Төв банк-Засгийн газрын эрх, үүрэг, хариуцлага, сангийн өгөөжийн норм, эрсдлийн менежементийн зэрэг харилцааг зохицуулах гэрээ байгуулж мөрдөнө)

3

ЭРДЭС БАЯЛАГЫН ҮНЭ ТӨЛӨВЛӨЖ БАЙСНААС ДАВЖ ӨССӨН ҮЕД ТОГВОРЖУУЛАЛТЫН САНД Х ӨРӨНГӨ ХУРИМТЛАГДАХ БӨГӨӨД ҮНЭ БУУРСАН ҮЕД УГ САНГААС Т ӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЖ БАЙХ



Төсөвлөгдсөн
Эрдэс баялгийн
орлого



Гүйцэтгэлээр
гарсан эрдэс
баялгийн орлого




	2012	2013	2014
Зэсийн үнийн төсөөлөл*	9837.5	9330	8330
Зэсийн тэнцвэржүүлсэн үнэ	6443	6970.8	7005.2
Боловсруулсан нүүрсний үнийн төсөөлөл*	201.6	183.5	175.5
Боловсруулсан нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ	151.1	158.8	160

*-Bloomberg


3 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН ЗАГВАР



- Энэхүү загварыг ихэнхи улс орнуудын тогтворжуулалтын сандаа ашигласан байна.
 - Тринидад Тобаго болон Чили улсын тогтворжуулалтын сангууд
 - Норвегийн Тэтгэвэрийн сангууд дээрх загвартай байдаг байна.

4 Монгол улсад тулгарч буй эрсдлүүд




- Манай улсын хувьд дараах гурван бүлэг эрсдэлийг авч үзлээ: (I) Макро эдийн засгийн тэнцвэргүй байдал болон валютын ханшны чангаралт, (II) Улс төрийн болон нийгмийн эрсдэл (III) Байгаль орчны эрсдэл.

4 Монгол улсад тулгарч буй эрсдлүүд

- Монгол улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой байдалд учрах аюул заналыг “монгол улсын эрсдэл” гэж үзэх бөгөөд энэ нь улс орныг хамарсан, улс орны салбаруудын хоорондын хамааралд нөлөөтэй, болон хэрхэн, хэзээ энэхүү аюул занал гарах нь тодорхойгүй, эдийн засаг, нийгмийн сөрөг нөлөөлөл ихтэй үзэгдлийг хэлэх бөгөөд эрсдлийг удирдах хариу үйлдэлд хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай болно. Энэхүү тодорхойлолтын элементүүдийг авч үзвэл:
- Улс орны хамрах хүрээ: Аливаа эрсдэл нь эдийн засаг, нийгмийн аливаа гурав болон түүнээс олон салбарт нөлөөлөх бөгөөд, эрсдлүүд нь нэг бүс нутгаас эсвэл аль нэг орон нутгаас гаралтай байх боловч түүний нөлөө нь улс орон даяар мэдэгдэнэ.
- Салбар хоорондын хамаарал: Гурав болон түүнээс олон салбаруудын хооронд нөлөөлөх нөлөөлөл.
- Тодорхой бус байдал: Эрсдэл нь 5 жилийн дотор хэрхэн гарах нь тодорхойгүй, түүний нөлөө нь хэдэн жил үргэлжлэх нь тодорхойгүй. (эрсдэл үүсэх магадлал болон түүний хүндрэлийг үнэлж гаргана)
- Эдийн засгийн нөлөө: Эрсдлийн нөлөөнөөс болж 1 тэрбум эсвэл түүнээс дээш эдийн засгийн алдагдал үүсэх чадвартай.
- Хамтын ажиллагаа: Эрсдлийн төвөгтэй байдлаас болж түүнийг бууруулахад олон талын хамтын ажиллагаа шаардагддаг. Эрсдлүүдийг таван янзаар ангилж болно: эдийн засгийн, геополитикийн, байгаль орчны, нийгмийн, технологийн эрсдлүүд.
- Эрсдлүүд нь бүгд адилхан бус. Энэхүү тайланд орж байгаа эрсдлийг мөн чанараар нь хоёр төрлийн эрсдэлд хувааж авч үзнэ:
- “**Байнгын, ужиг эрсдлүүд**” гэдэг нь энэ нь улс орны эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаанд урт хугацаанд үүсэх зогсонги байдал.
- “**Ноцтой**” эсвэл “**аливаа гэнэтийн үйл явдлаас үүсэлтэй эрсдлүүд**” байх бөгөөд тэдгээр нь нийгэмд үүсч бий болоход тодорхойлж болохуйц байдаг.

4 Монгол улсад тулгарч буй эрсдлүүд




Макро эдийн засгийн тэнцвэргүй байдалтай холбоотой эрсдэлүүдийн нөлөөлөл

	Шууд нөлөөлөл	Шууд бус нөлөөлөл
Засгийн газар дахь нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> • Өрийн дарамт • Валютын ханшийн хэлбэлзэл • Инфляцийн өсөлт 	
Нийгэм болон хүн ам дахь нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> • Тэгш бус байдал буюу давхражилтыг нэмэгдүүлэх, • Нийгэмд хуваарилалт шударга бус болох ба үүнтэй холбоотойгоор нийгмийн аюулгүй байдал нь хэрэглээ болон хадгаламжыг өсгөхгүй байх шалгаан болно 	
Бизнес дэхь нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> • Бизнесээ эрсдэлээс хамгаалах зардал нэмэгдэнэ. • Засгийн газрын санхүү болон тодорхой бус байдалтай холбоотойгоор банкны систем тогтворгүй болох 	

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум

4 Монгол улсад тулгарч буй эрсдлүүд




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Зураг 8. Улс төр, нийгмийн эрсдлийн нөлөө

Улс төр, нийгмийн эрсдлийн нөлөө		
	Шууд нөлөө	Шууд бус нөлөө
Засгийн газар дахь нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> Институци чанарт нөлөөлнө. Төрийн үйлчилгээнд хүнд суртал бий болно. Хууль сахиулах байгууллага авилгалд автана. Татварын орлого буурна Улс төрийн тогтвортой байдал алдагдана. Эдийн засаг дахь төрийн оролцоо нэмэгдэнэ. 	<ul style="list-style-type: none"> Улсын хөрөнгө оруулалтын үр өгөөж буурна. Тухайн орон нутгийн хөрөнгө оруулалтыг бууруулна.
Нийгэм, хүн ам дахь нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> Иргэдийн төрд итгэх итгэл буурна. Ур чадвар, оюуны хоцрогдол бий болох. 	<ul style="list-style-type: none"> Гэмт хэрэг нийгэмд газар авна.
Бизнес дэх нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагааны зардал нэмэгдэнэ. Хууль ёсны арилжаа алдагдана. Хөрөнгө оруулалтанд саад болох 	<ul style="list-style-type: none"> Аялал жуулчлал буурна. Өндөр зардалтай капитал Өрсөлдөөнийг хахууль сулруулна.

4 Монгол улсад тулгарч буй эрсдл үүд



Зураг 11. Байгаль орчны нийгэмд үзүүлэх нөлөөлөл

	Байгаль орчны эрсдлийн нөлөө	
Нөлөөлөл	Шууд нөлөө	Шууд бус нөлөө
Засгийн газрын нөлөө	-Эдийн засгийн хөгжлийн зогсонги байдал -Улс төрийн үймээн самуун -Тусламжийн хүнсний зардал -Эрчим хүчний аюулгүй байдалд тулгарч буй аюул	-Ажилгүйдэлтэй холбоотой нийгмийн зардал өсөх болон орлогын бууралт -Үндэсний аюулгүй байдлын эрсдэл/ байгалийн нөөцийн зөрчил
Нийгэм болон хүн амын нөлөө	-Өлсгөлөн болон ядуурлын түвшин өссөн -Хүрээлэн буй орчны хямрал -Хүнд хоол болон усны хомсдол -Нийгмийн үймээн самуун -Хүнсний үнийн огцом өсөлт	-Их нүүдлийн дарамт -Усны нөөцийн хомсдол
Бизнесийн нөлөө	-Экспортийн шахалт -Нөөцийн үнийн өсөлт -Эрчим хүч болон усны хязгаарлал	-Хөрөнгө оруулалтын алдагдсан боломжийн өртөг

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Анхаарал тавьсанд баярлалаа.
